



МОНГОЛ УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН
НИЙТ ШҮҮГЧИЙН ХУРАЛДААНЫ
ТОГТООЛ

2023 оны 10 сарын 09 өдөр

Дугаар 37

Улаанбаатар хот

Иргэний зориг ногоон нам (ИЗНН)-ын
дарга өөрчлөгдсөнийг бүртгүүлэх
тухай

Монгол Улсын дээд шүүхийн нийт шүүгчийн хуралдааныг Ерөнхий шүүгч Д.Ганзориг даргалж, танхимын тэргүүн Г.Алтанчимэг, Д.Мөнхтуяа, Ч.Хосбаяр, шүүгч Б.Амарбаясгалан, Г.Банзрагч, Д.Батбаатар, С.Батдэлгэр, М.Батсуурь, Х.Батсүрэн, Б.Батцэрэн, Н.Баярмаа, П.Золзаяа, М.Пүрэвсүрэн, С.Соёмбо-Эрдэнэ, Б.Цогт, Ц.Цогт, Х.Эрдэнэсүвд нарын бүрэлдэхүүнтэй хийсэн хуралдаанаар,

Иргэний зориг ногоон нам (ИЗНН)-аас гаргасан “Намын даргын мэдээлэлд өөрчлөлт оруулж, намын 10 дугаар Их хурлаар сонгогдсон Б.Батбаатарыг намын даргаар бүртгүүлэх” өргөдлийг шүүгч Г.Банзрагчийн илтгэснээр хэлэлцээд

ТОДОРХОЙЛОХ нь:

Иргэний зориг ногоон нам (ИЗНН)-ыг төлөөлж намын 10 дугаар Их хурлын “Их хурлын тогтоолын хэрэгжилтийг хангаж, холбогдох өөрчлөлтийг Улсын дээд шүүхийн улс төрийн намын бүртгэлд бүртгүүлэхийг тус намын даргаар сонгогдсон Б.Батбаатарт даалгах тухай” 06 дугаар тогтоолоор эрх (итгэмжлэл) олгогдсон этгээдээс 2023 оны 09 дүгээр сарын 18-ны өдөр 01/21 дүгээр албан бичгээр Улсын дээд шүүхэд өргөдөл гаргасан.

Уг өргөдөлд “... Иргэний зориг ногоон намын Үндэсний хорооны 2023 оны 08 дугаар сарын 05-ны өдрийн хурлын 04 дүгээр тогтоолын дагуу 2023 оны 09 дүгээр сарын 09-ний өдөр намын 10 дугаар Их хурлыг зарлан хуралдуулсан. Энэхүү хурлаар намын даргад нэр дэвшигчийг сонгох асуудлаар нууцаар санал хураалт явуулахад Батын Батбаатар 93.2 хувийн саналаар дэмжигдсэн тул намын 10 дугаар Их хурлын 05 дугаар тогтоолоор Иргэний зориг ногоон намын даргаар Б.Батбаатарыг батламжилсан. Иймд Монгол Улсын дээд шүүхийн улс төрийн намын бүртгэлд Иргэний зориг ногоон намын даргын мэдээллийг өөрчилж, тус намын даргаар Б.Батбаатарыг бүртгэж өгнө үү ...” гээд нийт 181 хуудас бүхий 66 баримт, 1 ширхэг CD ирүүлжээ.

Өргөдлийг хүлээн авсан шүүгч Улсын дээд шүүхийн нийт шүүгчийн хуралдааны 2021 оны 09 дүгээр тогтоолоор батлагдсан “Улс төрийн намын бүртгэл хөтлөх журам”-ын 3.2-ын дагуу 2023 оны 09 дүгээр сарын 25-ны өдөр бүрдүүлбэр хангуулахаар албан бичиг явуулахад, тус намаас 2023 оны 09 дүгээр сарын 28-ны өдөр холбогдох тайлбар, баримтыг ирүүлсэн байна.

Ийнхүү өргөдөл гаргагчийн ирүүлсэн баримт нь Улс төрийн намын бүртгэл хөтлөх журмын Хавсралт №2А-д заасан бүрдүүлбэрийн шаардлагыг хангасан тул журмын 3.18-д зааснаар шүүгчээс холбогдох бэлтгэл ажлыг гүйцэтгэн, Нийт

шүүгчийн хуралдаанаар хэлэлцүүлэх саналыг гаргасны дагуу холбогдох өргөдлийг хэлэлцэв.

Иргэний зориг ногоон намаас гаргасан энэхүү өргөдөлтэй холбогдуулж тус намын Сүхбаатар дүүргийн намын хорооны дарга гэх А.Баярхүүгээс 2023 оны 09 дүгээр сарын 20-ны өдрийн А23/07 дугаар албан бичгээр гомдол гаргасан байна. Үүнд:

- "... Үндэсний хороо нь 2015 оны Их хурлаар дүрмийн дагуу байгуулагдсан 219 гишүүнтэй байх ёстой. Гэтэл Үндэсний хорооны 2023 оны 8 сарын хурал бүтэц, бүрэлдэхүүний хувьд зохих хувь хэмжээнд хүрэхгүй, хүчин төгөлдөр бус. Тус Үндэсний хорооны хурлын ирцийг бүрдүүлэхдээ олонх намын хорооноос хуурамч тогтоол гарган, ирцийг цөөн тоотойгоор бүрдүүлж, гишүүн бус хүмүүсийг тоонд оруулах явдал ихээхэн гарсан. Мөн онлайнаар оролцогсдын тоо, бүрэлдэхүүн ихээхэн эргэлзээтэй байсан.

- Намын дүрмийн 7.1.3-т намын гишүүний эрх, үүргийг "... намын удирдах дээд болон Төлөөллийн төв байгууллагын бүрэлдэхүүнийг сонгоход оролцох" гэж заасан. Гэтэл 8 жилийн дараа хийгдэж байгаа намын Их хуралд гишүүдийн оролцох эрхийг хэт боомилон багасгаж, тухайн аймаг, дүүргээс Үндэсний хороонд сонгогдож болох гишүүдийн тооноос ихгүй байхаар квот тогтоосон нь намын гишүүдийн сонгох, сонгогдох эрхийг зөрчсөн шийдвэр болсон.

- Намын дэргэдэх Эмэгтэйчүүд, Залуучууд, Ахмадын зөвлөлийн хурлыг хийхдээ зохион байгуулагчид нь зарим аймаг, дүүргийн төлөөлөгчдийг (тухайлбал Сүхбаатар дүүргийн төлөөллийг) оруулалгүй хассан нь намын дүрэм, гишүүдийн эрхийг зөрчсөн үйлдэл болсон.

- Намын Их хурлаар дүрэмд заасан тайлангууд тавигдаагүй, гишүүдийн үг хэлэх, санал оруулах зэрэг олон эрхүүд зөрчигдсэн ба намын даргын сонгуулиас өмнө Б.Батбаатар өөрийгөө намын дарга хэмээн өргөмжлөн ярьж бичсэн нэрийн хуудас тараасан зэрэг үйлдэл нь шударга бус хурал, сонгууль явагдах нөхцөлийг бүрдүүлсэн ..." гээд намын Их хурал болон гарсан шийдвэрийг эсэргүүцэж буй 9 гишүүний нэрс бүхий баримтыг хавсарган ирүүлсэн байна.

Мөн тухайн иргэнээс 2023 оны 09 дүгээр сарын 22-ны өдрийн А23/08 дугаар албан бичгээр "... Танай www.supremecourt.mn веб сайтад "Иргэний зориг ногоон намын даргыг бүртгүүлэх өргөдөл ирүүллээ" гэсэн утга бүхий мэдээ гарчээ. Энэхүү мэдээнээс харахад ИЗНН-ыг төлөөлж хэн өргөдөл гаргасан нь тодорхойгүй байна. Манай намыг итгэмжлэлгүйгээр төлөөлөх этгээдийн нэр, гарын үсэг, гараар бичсэн өргөдөл байхгүй байхад ИЗНН-ын өргөдөл гэгчийг хүлээж авснаараа танай байгууллага манай намын даргын эрх мэдлийг дур мэдэн, дүрэм зөрчин булаан авахаар санаархаж буй этгээдэд үйлчилсэн алхам боллоо гэж танайд гомдол гаргаж байна. Ийм учраас намыг итгэмжлэлгүйгээр төлөөлөх этгээд гэж танайд бүртгэлтэй байгаа Ц.Ганхуягийн гаргасан өргөдлөөс өөр өргөдлийг ИЗНН-ын гишүүд бид хүлээн зөвшөөрөхгүй гэдгээ илэрхийлж байна. Ц.Ганхуягийг ИЗНН-ын даргаас чөлөөлөх намын Их хурал болоогүй байгаа. Б.Батбаатартай холбоотой өргөдөлд дурдагдсан асуудлаар намын дүрэм доорх байдлаар зөрчигдсэн болно. Үүнд:

- Намын Их хурлыг товлон зарлах үүрэгтэй Үндэсний хорооны хуралдааныг намын Улс төрийн зөвлөл зарлаагүй. Уг хурлыг намын дарга Ц.Ганхуяг зарлах ёстой.

- Б.Батбаатарыг намын даргаар сонгосон гэх намын Их хурал гээчийг ИЗНН-ын хүчин төгөлдөр ажиллаж буй Үндэсний хороо товлон зарлаагүй. Хэрэв Үндэсний хороо үнэхээр хуралдаж зарлах байсан бол Намын дүрмийн 20.3-т заасан бүрэлдэхүүнд хурлын зарыг 7 хоногийн өмнө Улс төрийн зөвлөлийн шийдвэр

хэлбэрээр түгээх ёстой байсан. ИЗНН-ын ээлжит Их хурал цаг хугацаандаа явагдаагүй сүүлийн хэдэн жилийн үйл ажиллагааны доголдлыг Б.Батбаатар овжиноор ашиглаж, намын гишүүд бидний эвлэлдэн нэгдэх эрхийг алдагдуулж байгааг засаж залруулахад тусална уу. Иймээс ИЗНН-ын Их хурлын талаар Б.Батбаатар нарын бүрдүүлсэн материал зөрчилтэй байгааг үндэслэн Б.Батбаатарыг Иргэний зориг ногоон намын даргаар бүртгэхээс татгалзсан шийдвэр гаргаж өгөхийг хүсье ...” гэжээ.

ҮНДЭСЛЭХ нь:

Улсын дээд шүүхийн нийт шүүгчийн хуралдаанаас дараах үндэслэлээр Иргэний зориг ногоон нам (ИЗНН)-ын дарга өөрчлөгдсөнийг бүртгэж шийдвэрлэлээ.

Улс төрийн намын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4.“дотоод асуудлаа ардчилсан зарчмыг баримтлан олонхийн саналаар шийдвэрлэх”, 11 дүгээр зүйлийн 11.1.“Намын дотоод зохион байгуулалт, удирдлагын тогтолцоог намын дүрмээр зохицуулна”, 11.2.“Намын дүрэмд дараахь нийтлэг зүйлийг тусгана: 11.2.5.намын Их болон бусад хуралд төлөөлөгч сонгох, оролцох, удирдах болон хяналтын байгууллага байгуулах, тэдгээрийн бүтэц, зохион байгуулалт, үйл ажиллагааны тухай”, 13 дугаар зүйлийн 13.1.“Намын удирдах дээд байгууллага нь намын Их Хурал байна” гэж тус тус заасан, энэ тохиолдолд ИЗНН-ын ээлжит Их хурал хуралдаж, намын даргыг сонгосон нь дээрх хуулийн зохицуулалт болон тус намын дүрэмд нийцсэн байна.

Тодруулбал, ИЗНН-ын дүрмийн (цаашид “Намын дүрэм” гэх) 18.1-д “Намын Удирдах дээд байгууллага нь Улс төрийн намын тухай хуульд заасны дагуу тус намын “Их хурал” байна”, 19.1-д “Дараахь асуудлыг Улс төрийн намын тухай хуульд заасны дагуу намын Их хурлаар хэлэлцэж шийдвэрлэнэ. Үүнд: 19.1.2. намын даргыг сонгох, чөлөөлөх;” гэж заасан бөгөөд уг дүрмийн дагуу намын ээлжит Их хурлыг дараах үе шаттайгаар зохион байгуулахаар байна: Үүнд:

1. Улс төрийн зөвлөл Үндэсний хорооны хурлын товыг тогтоох ба хурал болохоос 7-оос доошгүй хоногийн өмнө гишүүдэд зарлана. (Дүрмийн 21.1.)
2. Үндэсний хорооны хурлаар намын Их хурлыг зарлан хуралдуулах тов, түүнд оролцуулах төлөөлөгчийн тоог тогтооно. (Дүрмийн 18.3)
3. Их хуралд оролцох төлөөлөгчдийн гуравны хоёр нь хүрэлцэн ирснээр хурал хүчин төгөлдөр болох ба хуралд оролцогчдын олонхийн саналаар шийдвэр хүчин төгөлдөр болно (Дүрмийн 19.2).

Өргөдөлд хавсарган ирүүлсэн баримтуудыг үзвэл, ИЗНН-ын 10 дугаар Их хурал нь дээрх намын дүрэмд заасан журмын дагуу явагдсан байна.

2023 оны 07 дугаар сарын 29-ний өдөр ИЗНН-ын Улс төрийн зөвлөл хуралдаж, 08 дугаар тогтоолоор Намын дүрмийн 21.1, 25.5, 26.1.7-г тус тус баримтлан Үндэсний хорооны хурлыг 2023 оны 08 дугаар сарын 05-ны өдрийн 11 цагт зарлан хуралдуулахаар шийдвэрлэж, Үндэсний хорооны гишүүдэд хурлын товыг тухайн өдөр буюу хурал болохоос 7 хоногийн өмнө мэдэгдсэн байна (хавсралт 92-99).

Намын дүрмийн 21.1-д “Үндэсний хорооны хуралдаан ээлжит буюу ээлжит бус байж болно. Ээлжит хуралдааныг жилд 1 удаа зарлан хуралдуулна. Хурлын товыг Улс төрийн зөвлөл тогтоох ба хурал болохоос 7-оос доошгүй хоногийн өмнө гишүүдэд зарлана ...”, 25.5-д “Хурлын шийдвэр тогтоол хэлбэртэй байна. Тогтоолд хурал даргалагч гарын үсэг зурна ...” 26.1.7-д “... хэрэв тухайн асуудал Их хурлын болон Үндэсний хорооны бүрэн эрхэд хамаарахаар бол тэдгээр байгууллагад санал оруулж, шийдвэрлүүлэх” гэж тус тус заажээ.

Намын дүрмийн 22.1.3-т зааснаар Улс төрийн зөвлөлийн гишүүдийг сонгох, чөлөөлөх, эгүүлэн татах нь Үндэсний хорооны бүрэн эрхэд хамаарна; 25.2.“Улс төрийн зөвлөлийг Үндэсний хорооны гишүүдээс бүрдүүлэх ба 35 хүртэл гишүүнтэй байна. Улс төрийн зөвлөлийн бүрэлдэхүүнд энэ дүрмийн 27.1-д заасан намын удирдлагууд албан тушаалаараа орно”; 25.3.“Улс төрийн зөвлөлийн хурлыг улиралд 1-ээс доошгүй удаа зарлан хуралдуулна. Шаардлагатай гэж үзвэл намын дарга, Улс төрийн зөвлөлийн нийт гишүүдийн гуравны нэгээс доошгүй хэсгийн шаардсанаар Улс төрийн зөвлөлийн ээлжит бус хурлыг хэдийд ч зарлан хуралдуулж болно”; 25.4.“Энэ дүрэмд өөрөөр заагаагүй бол Улс төрийн зөвлөлийн нийт гишүүдийн олонх нь хүрэлцэн ирснээр хурал хүчин төгөлдөр болох ба хуралд оролцогчдын олонхийн саналаар шийдвэр хүчин төгөлдөр болно”; 25.6.“Улс төрийн зөвлөлийн бүрэн эрхийн хугацаа Үндэсний хорооны бүрэн эрхийн хугацаагаар тодорхойлогдоно”.

Хамгийн сүүлийн байдлаар ИЗНН-ын Үндэсний хорооны хурлын 2018 оны 01 дүгээр сарын 27-ны өдрийн “Улс төрийн зөвлөлийн гишүүнээс чөлөөлж, сонгох” тухай 11 дүгээр тогтоолоор тус зөвлөлийг 19 гишүүнээр бүрдүүлсэн байна. (Нэмэлт баримт х.16-17). Гэвч уг 19 гишүүдээс өөрсдийн хүсэлтээр Улс төрийн зөвлөл болон Үндэсний хорооноос чөлөөлөгдсөн, намын гишүүнээс гарсан зэрэг шалтгаанаар 10 гишүүн үлдсэн гэсэн тайлбар, холбогдох судалгаа, баримтыг өргөдөл гаргагчаас ирүүлсэн бөгөөд энэ нь тус шүүхэд хадгалагдаж буй намын хувийн хэргийн 4 дэх хавтасны 197, 204 зэрэг хуудсуудаар давхар нотлогдож байна.

Үндэсний хорооны 2018 оны 11 дүгээр тогтоолоор сонгогдсон 19 гишүүнээс үлдсэн 10 гишүүний 8 нь буюу 80 хувь нь 2023 оны 07 дугаар сарын 29-ний өдрийн Улс төрийн зөвлөлийн хуралд оролцож (хавсралтаар ирүүлсэн баримтад “цахимаар-3, танхимаар-5, нийт 8 гишүүн оролцсон” гэж тэмдэглэж, баталгаажуулсан), 08 дугаар тогтоолыг 100 хувийн саналаар гаргасныг Намын дүрмийн 25.4-т нийцсэн гэж үзлээ. Нэгэнт өөрсдийн хүсэлтээр намаас гарсан, Үндэсний хороо болон Улс төрийн зөвлөлөөс чөлөөлөгдсөн гишүүдийг хуралд оролцуулах боломжгүйгээс гадна Намын дүрэмд Улс төрийн зөвлөлийн гишүүдийн тоог хатуу заагаагүйг дурдах нь зүйтэй.

Түүнчлэн, Улс төрийн зөвлөлийн хурлын тогтоолд Б.Батбаатар гарын үсэг зурсныг тодруулахад, “2018 оны 01 дүгээр сарын 27-ны өдрийн Үндэсний хорооны хурлын 08 дугаар тогтоолоор Намын дэд даргаар сонгогдсон тул намын дүрмийн 27.1-ийн дагуу албан тушаалаараа Улс төрийн зөвлөлийн бүрэлдэхүүнд орсон” гэсэн тайлбар өгч, холбогдох баримтыг ирүүлсэн болно.

I. Улс төрийн зөвлөлийн товлосон 2023 оны 08 дугаар сарын 05-ны өдөр Үндэсний хорооны хурал болж, 04 дүгээр тогтоолоор Намын дүрмийн 18.3, 18.4, 21.4, 21.5-д заасныг тус тус баримтлан намын Их хурлыг 2023 оны 09 дүгээр сарын 09-ний өдөр хуралдуулахаар товлж, хуралд оролцох төлөөлөгчдийн тоог нийт 288 гишүүн байхаар тогтоожээ. Хурлын зарыг Өдрийн сонин 2023.08.07-ны №144-т нийтэлснээс гадна, 2023 оны 08 дугаар сарын 05-ны өдөр ИЗНН-ын фэйсбүүк хаягаас “намын Үндэсний хороо хуралдаж намын Их хурлыг 2023 оны 09 дүгээр сарын 09-ний өдөр хуралдуулахаар шийдвэрлэсэн талаар, мөн 2023 оны 08 дугаар сарын 25-ны өдөр намын Их хурлын урьдчилсан хөтөлбөрийн талаар, 2023 оны 08 дугаар сарын 29-ний өдөр “...Намын Их хуралд оролцох хүсэлтэй гишүүд өөрийн харьяалагдах аймаг, дүүргийн дарга нартай болон дэргэдэх байгууллагын ажлын хэсгүүдтэй уулзан хурлын тов цаг мэдээлэлтэй танилцан хуралд нь оролцож албан ёсоор төлөөлөгчөөр сонгогдох боломжтой болохыг мэдэгдье. Ажлын хэсэг” гэсэн мэдээллийг тавьжээ (хавсралт х.45-47).

Үндэсний хорооны хурлын дээрх 04 дүгээр тогтоолд баримталсан Намын дүрмийн 18.3-т “Их хурлыг зарлан хуралдуулах тов түүнд оролцуулах төлөөлөгчийн тоог Үндэсний хороо тогтооно”; 18.4-т “Үндэсний хорооны нийт гишүүдийн 50%+1-ээс дээш хувийн саналаар ээлжит бус Их хурлыг зарлан хуралдуулж болно ...”; 21.4-т “Үндэсний хорооны гишүүдийн олонх хүрэлцэн ирснээр хурал хүчин төгөлдөр болох ба энэ дүрмийн 22.2-т зааснаас бусад тохиолдолд хуралд оролцогчдын олонхийн саналаар шийдвэр хүчин төгөлдөр болно”; 21.5-д “Үндэсний хорооны хурлаас гарах шийдвэр тогтоол хэлбэртэй байна. Тогтоолд хурлын дарга, Тэргүүлэгчид гарын үсэг зурж баталгаажуулна ...” гэсэн байна.

Мөн дүрмийн 19.1.4-ийн дагуу Үндэсний хороог сонгож байгуулах нь намын Их хурлын бүрэн эрхэд хамаарна; 20.2-т зааснаар “Үндэсний хороо 219 хүртэл гишүүнтэй байна”; 21.6. “Үндэсний хорооны хуралдааны дэгийг тухайн Үндэсний хороо өөрөө тогтооно”; 22.1.2-ын дагуу Үндэсний хороо нь “Үндэсний хорооны гишүүн орон гарах тохиолдолд түүний оронд санал болгосон гишүүнийг хэлэлцэж шийдвэрлэх” эрхтэй.

ИЗНН-ын 9 дүгээр Их хурлын 2015 оны 03 дугаар сарын 09-ний өдрийн 09 дүгээр тогтоолын хавсралтаар Үндэсний хорооны 124 гишүүнийг баталсан байдаг. Гэвч өргөдөл гаргагчаас “үүнээс хойш Хорооноос өөрсдийн хүсэлтээр гарсаар 103 гишүүн үлдсэн, намын дүрмийн дагуу Үндэсний хороо нь орон гарсан гишүүнийг шийдвэрлэх эрхтэй” гэсэн тайлбар өгч, холбогдох баримтыг ирүүлсэн (хавсралт х.87-91, 92-99, нэмэлт баримт х.28-31) боловч эдгээр 103 гишүүнийг албажуулсан баримт байхгүй, тухайлбал Намын дүрмийн 22.1.2-ын дагуу Үндэсний хорооноос шийдвэр гараагүй байх тул энэ тооноос хурлын ирцийг тооцох боломжгүй. Гэхдээ нэгэнт өөрсдийн хүсэлтээр намаас гарсан, Үндэсний хорооноос чөлөөлөгдсөн гишүүдийг хуралд оролцохыг шаардах боломжгүй тул намын Их хурлын 2015 оны 09 дүгээр тогтоолоор сонгогдсон 124 гишүүнээс өнөөдрийн байдлаар идэвхтэй байгаа нийт гишүүдийн тооноос тооцох нь зүйтэй юм. Мөн Намын дүрмийн 20.2-т Үндэсний хороо 219 хүртэл гишүүнтэй байхаар заасан, өөрөөр хэлбэл тодорхой тоог хатуу заагаагүй байна.

Өргөдөл гаргагчаас ирүүлсэн Үндэсний хорооны гишүүн гэх 103 хүний нэрсийг намын 9 дүгээр Их хурлын 09 дүгээр тогтоолын хавсралтаар батлагдсан 124 хүнтэй тулгахад 91 нь таарч байна. Үүнээс 2023 оны 08 дугаар сарын 05-ны өдрийн Үндэсний хорооны хуралд 51 гишүүн нь оролцсон, тодруулбал хуралд оролцсон гэх 61 гишүүний 51 нь 2015 онд Их хурлаас сонгогдсон гишүүд байна. Иймд Үндэсний хорооны хуралд “албан ёсны” 91 гишүүнээс 51 нь буюу 56 хувь нь хуралд оролцож, олонхийн саналаар шийдвэр гаргасан нь Намын дүрмийн 21.4-т нийцсэн гэж үзлээ.

2023 оны 08 дугаар сарын 05-ны өдрийн Үндэсний хорооны хурлаас “Үндэсний хорооны хурал даргалагч, хурлын тэргүүлэгч гишүүнийг сонгогдсоныг батлах тухай” 01, “Тооллогын комиссыг байгуулж, редакцын комиссын гишүүн томилсон тухай” 02, “Үндэсний хорооны хурлын хэлэлцэх асуудлыг баталсан тухай” 03, “Намын Их хурлын тов, хуралд оролцох төлөөлөгчдийн тоог тогтоох, хурлын товыг зарлах тухай” 04, “Их хурал зохион байгуулах ажлын хэсгийн бүрэлдэхүүн, ажлын хэсгийн 2 гишүүнийг Улс төрийн зөвлөлийн хурлаар хэлэлцэж шийдвэрлэхийг даалгасан тухай” 05, “Их хуралд оролцох гишүүдийн тоог хурал зохион байгуулах ажлын хэсгээр шийдвэрлүүлэх, тогтсон квотын дагуу Их хуралд оролцох төлөөлөгчдийг томилохыг бүх шатны байгууллага, удирдлагуудад үүрэг болгох тухай” 06 дугаар бүхий, нийт 6 тогтоол гарсан байна.

Үндэсний хорооны хурлын 2023 оны 05 дугаар тогтоолын дагуу Их хурал зохион байгуулах ажлын хэсгийн хурлын 2023 оны 08 дугаар сарын 16-ны өдрийн 01 дүгээр тогтоолоор Намын дүрмийн 21.6-д заасныг баримтлан “Намын Их хуралд

оролцох гишүүдийн тоо (квот)-г Намын удирдлага 5, Аймгийн намын хорооноос тус бүр 6, Дүүргийн намын хорооноос тус бүр 10, Намын дэргэдэх байгууллага тус бүр 10, Нийслэлийн намын хороо 5, Хэрэг эрхлэх газар 5, Намын даргын ажлын алба 7, Намын даргын зөвлөх 10 төлөөлөгч тус тус оролцуулахаар тогтоож, нэрсийг 2023 оны 09 дүгээр саны 04-ний дотор Хэрэг эрхлэх газарт ирүүлэхийг холбогдох намын байгууллагуудад үүрэг болгосон. Үүний дагуу ИЗНН-ын Нийслэлийн намын хорооны даргын тушаал, намын Хэрэг эрхлэх газар, Ахмадын хороо, Эмэгтэйчүүдийн холбоо, Залуучуудын холбоо, Оюутны холбооны хурлын тогтоолууд, Нийслэлийн намын хороо, Баянгол, Баянзүрх, Багахангай, Багануур, Налайх, Сүхбаатар, Сонгинохайрхан, Чингэлтэй, Хан-Уул дүүргүүдийн намын хорооны Бага хурлын тогтоолууд, Архангай, Баянхонгор, Баян-Өлгий, Говь-Алтай, Говьсүмбэр, Дархан-Уул, Дорнод, Дорноговь, Дундговь, Завхан, Орхон, Өмнөговь, Өвөрхангай, Сүхбаатар, Сэлэнгэ, Төв, Увс, Ховд, Хөвсгөл, Хэнтий аймгуудын намын хорооны Бага хурлын тогтоолуудаар намын 10 дугаар Их хуралд оролцох гишүүдийн нэрсийг ирүүлжээ. Үүнээс үзвэл Үндэсний хороо Их хурлын гишүүдийг сонгохдоо Намын дүрмийн 7.1.3-т заасан гишүүний эрх болон намын байгууллагын бүх шатны төлөөллийг хангах зарчмыг зөрчсөн гэж үзэхээргүй байна (хавсралт х.103-139).

Мөн шүүхийн ажилтнаас хийсэн сонсох ажиллагааны явцад хуралд оролцсон гэх Үндэсний хорооны гишүүдээс түүврийн аргаар сонгогдсон 20 хүнтэй утсаар ярихад бүгд “хуралд оролцсон” гэж хариулсныг тэмдэглэв.

II. Үндэсний хорооны товлосон өдөр буюу 2023 оны 09 дүгээр сарын 09-ний өдөр ИЗНН-ын 10 дугаар Их хурал хуралдаж, Намын дүрмийн 19.1.2, 19.2-ыг тус тус баримтлан “Намын даргаар Батын Батбаатар сонгогдсоныг батламжилсан тухай” 05 дугаар тогтоол гаргасан (хавсралт х.12).

Мөн тус хурлаас “Их хурлын тэргүүлэгч, даргалагчийг томилох тухай” 01, “Тооллогын комиссын гишүүн, даргыг томилох тухай” 02, “Редакцын комиссын гишүүн, даргыг томилох тухай” 03, “Иргэний зориг ногоон намын 10 дугаар Их хурлын хэлэлцэх асуудлыг батлах тухай” 04 (1. Намын даргыг сонгох, 2.Үндэсний хороог сонгож байгуулах, 3.Хяналтын төв байгууллагын бүрэлдэхүүнийг сонгох), “Их хурлын тогтоолын хэрэгжилтийг хангаж, холбогдох өөрчлөлтийг Улсын дээд шүүхийн улс төрийн намын бүртгэлд бүртгүүлэхийг тус намын даргаар сонгогдсон Б.Батбаатарт даалгах тухай” 06 дугаар бүхий, нийт 6 тогтоол гаргажээ.

Түүнчлэн, Их хурлын Тооллогын комиссоос “Редакцын комиссын гишүүдийг сонгох асуудлыг хэлэлцсэн тухай” 01, “Намын 10 дугаар Их хурлаар хэлэлцэх асуудлын талаар санал хураалт явуулсан дүнгийн тухай” 02, “Намын даргад нэр дэвшигчийг сонгох асуудлаар нууцаар санал хураалт явуулсан дүнгийн тухай” 05 дугаар тогтоолыг гаргасан байна.

Намын дүрмийн 19.2-т зааснаар “Их хуралд оролцох төлөөлөгчдийн гуравны хоёр нь хүрэлцэн ирснээр хурал хүчин төгөлдөр болох ба хуралд оролцогчдын олонхийн саналаар шийдвэр хүчин төгөлдөр болно.”

Өргөдөл гаргагчаас ирүүлсэн Их хурлын тэмдэглэлд “... Намын Их хуралд оролцох 288 төлөөлөгчөөс 204 төлөөлөгч буюу 70,8 хувийн ирцтэйгээр хуралдав ...” гэж бичсэн, хуралд оролцсон төлөөлөгчдийн ирцийн тэмдэглэлд 288 гишүүний 204 нь гарын үсэг зурсан байна (хавсралт х.16-33, х.34-44). Мөн намын Их хурлын явцыг харуулсан фото зургууд, CD бичлэг зэргийг ирүүлсэн. Түүнчлэн шүүхийн ажилтнаас хийсэн сонсох ажиллагааны явцад түүврийн аргаар сонгогдсон 30 хүнтэй утсаар ярихад бүгд “ИЗНН-ын гишүүн мөн, Их хуралд оролцсон” гэж хариулжээ.

Иймээс намын Их хуралд оролцох нийт 288 төлөөлөгчийн 204 нь буюу 70,8 хувь оролцсоноор хурал хүчин төгөлдөр болсон бөгөөд “Намын даргаар Батын

Батбаатар сонгогдсоныг батламжилсан тухай” 05 дугаар тогтоолыг 180 гишүүний саналаар буюу хуралд оролцсон нийт төлөөлөгчдийн 88.2 хувиар баталсан нь Намын дүрмийн 19.2-т нийцжээ.

Намын Их хурлын 05 дугаар тогтоолд ИЗНН-ын дарга асан Ц.Ганхуягийг чөлөөлсөн заалт байхгүй боловч, агуулгын хувьд намын Их хурлаас шинэ дарга сонгогдсоноор өмнөх даргын бүрэн эрх дуусгавар болохоос гадна 2023 оны 06 дугаар сарын 05-ны өдөр Ц.Ганхуягаас Үндэсний хороонд хандан Намын дүрмийн 22.1.16-д заасны дагуу өөрийн хүсэлтээр намын даргаас чөлөөлөгдөх тухай хүсэлт гаргасан байна.

Өргөдөл гаргагч өөрийн гаргасан баримтын үнэн зөвийг хариуцах ба гомдол гаргагч иргэн А.Баярхүү чухам ямар баримтыг зөрчилтэй гэж үзэж байгаа нь тодорхойгүй, нотлох баримтгүйг дурдаад, дээрх хууль зүйн болон бодит үндэслэлээр түүний гаргасан гомдол үгүйсгэгдэж буйг тэмдэглэв.

Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.8.8, 26 дугаар зүйлийн 26.1-д заасныг удирдлага болгон ТОГТООХ нь:

1. Улс төрийн намын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4, 11 дүгээр зүйлийн 11.1-д заасныг баримтлан Иргэний зориг ногоон нам (ИЗНН)-ын даргаар Б.Батбаатарыг бүртгэсүгэй.

2. Өргөдөл гаргагчаас улсын тэмдэгтийн хураамжид төлсөн 150,000 төгрөгийг улсын орлогод хэвээр үлдээсүгэй.

ХУРАЛДААН ДАРГАЛАГЧ,
ЕРӨНХИЙ ШҮҮГЧ

Д.ГАНЗОРИГ

ИЛТГЭГЧ ШҮҮГЧ

Г.БАНЗРАГЧ